



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/146

Шивээговь сум

Тамхи худалдан борлуулах тусгай  
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.4 дэх заалт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 86 дугаар тогтоол “Сумын нутаг дэвсгэрт тамхины худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-ын 2.1, 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах “Шивээ нуман шарга” ХХК-ийн “Төгрөг маркет” хүнсний дэлгүүрт тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийг 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 2 жилийн хугацаатай олгосугай.

2. Тусгай зөвшөөрлийн хураамж болох 250000 /хоёр зуун тавин мянга/ төгрөгийг Орон нутгийн орлогод төвлөрүүлж, хяналт тавьж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Мөнхцэцэг)-т үүрэг болгосугай.

3. “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль” болон “Тамхины хяналтын тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийг мөрдөж ажиллахыг “Шивээ нуман шарга” ХХК-ийн захирал (Э.Ариунгэрэл)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ